



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВД

## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.05.02 № 03/3402  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ДҮТ/20240202022 дугаартай “Сэлбэг хэрэгсэл худалдан авах” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Агт ханлиг” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох материалд үндэслэн хянан үзлээ.

“Агт ханлиг” ХХК-ийн гомдолд тус компанийн тендерээс тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д заасан санхүүгийн чадавхын шаардлага, ТШЗ 19.1-д заасан техникийн чадавх болон ижил, төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын шаардлагыг хангаагүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэрийг зөвшөөрөхгүй байна. Мөн гэрээ байгуулах эрх олгосон “Энержи дистрибьюшин” ХХК-ийн тендерт ТШЗ 19.1-д заасан захиалагчийн тодорхойлолтыг ирүүлээгүй нь байхад шалгаруулсан нь ашиг сонирхолтой байх тул захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна.

Нэг. Гомдолд дурдсаны дагуу “Агт ханлиг” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д “...1. Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртөг (59.7 сая төгрөг)-ийн 100 хувь болон түүнээс багагүй байна. 2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна. 3. Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна.” гэж заасан байна.

Цахим санхүүгийн тайлан /e-balance.gov.mn/-аас үзэхэд “Агт ханлиг” ХХК-ийн санхүүгийн тайланд борлуулалтын орлогын хэмжээ 2022 онд 0 төгрөг, 2023 онд 287.0 сая төгрөг байна.

Үнэлгээний хорооны 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлд “Агт ханлиг” ХХК-ийн 2022 болон 2023 оны борлуулалтын орлого тус бүр “0” төгрөг байгаа нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн

9766005931

хүснэгтийн дээр дурдсан шаардлагыг хангаагүй гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д "...Ижил төстэй гэрээний туршлага: 2022, 2023 онуудад жил тус бүрд тухайн батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг доод тал нь 1 удаа нийлүүлсэн байх шаардлагатай. Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, хүлээлгэж өгсөн актын хуулбар, тухайн барааг цаг хугацаанд нь чанартай нийлүүлсэн талаарх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ..." гэж заасан байна.

"Агт ханлиг" ХХК-ийн тендерт 2023 оны 97.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий "Серверийн өрөөний тоноглол, сэлбэг хэрэгсэл" нийлүүлэх гэрээ, гэрээ дүгнэсэн акт, захиалагчийн тодорхойлолтыг хавсарган, 2022 онд гүйцэтгэсэн ижил, төстэй бараа нийлүүлсэн туршлагын мэдээлэл ирүүлээгүй нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн дээр дурдсан шаардлагыг хангаагүй гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

Хоёр. "Агт ханлиг" ХХК-ийн гомдолд дурдсаны дагуу "Энержи дистрибьюшин" ХХК-ийн тендерийг хянан үзэхэд 2021-2023 онд гүйцэтгэсэн ижил, төстэй ажлын гэрээ, хүлээлцсэн акт зэрэг материалын хуулбарыг хавсарган, холбогдох захиалагчийн тодорхойлолтыг ирүүлээгүй байхад тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн дээр дурдсан ТШЗ 19.1-д заасан шаардлагыг хангасан гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

Иймд захиалагчийн 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/497 тоот шийдвэрийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтын дагуу хүчингүй болгож байна.


Дээрх тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтад үндэслэн мэдэгдье.

"Агт ханлиг" ХХК-ийн албан бичигт дурдсан захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон "Энержи дистрибьюшин" ХХК-ийг захиалагчтай ашиг сонирхлын зөрчилтэй гэх асуудлаар тухайн асуудлыг хянах эрх бүхий хууль хяналтын байгууллагад хандана уу.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түр түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "Агт ханлиг" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ